

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Унага цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/56/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт.....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 37
танай _____-ны № _____-г

УНАГА ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б.ОЮУНБАЙГАЛЬ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Унага цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Унага цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>56 935 724,00</u>	<u>53 854 595,00</u>
33	АВЛАГА	<u>1 325 979,00</u>	<u>5 000,00</u>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1 320 979,00	-
335	Бусад авлага	<u>5 000,00</u>	<u>5 000,00</u>
3351	Байгууллагаас авах авлага	5 000,00	5 000,00
35	БАРАА МАТЕРИАЛ	<u>55 609 745,00</u>	<u>53 849 595,00</u>
351	Түүхий эд материал	<u>53 935 645,00</u>	<u>53 794 695,00</u>
35110	Тусгай зориулалттай материал	53 935 645,00	53 794 695,00
354	Хангамжийн материал	<u>1 674 100,00</u>	<u>54 900,00</u>
35410	Бичиг хэргийн материал	134 500,00	-
35420	Аж ахуйн материал	732 500,00	-
35460	Хүнсний материал	410 100,00	54 900,00
35470	Бусад хангамжийн материал	397 000,00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2 141 713 011,16</u>	<u>2 079 554 870,38</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>2 141 713 011,16</u>	<u>2 079 554 870,38</u>
392	Биет хөрөнгө	<u>1 831 558 011,08</u>	<u>1 769 537 370,26</u>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1 810 199 959,53	1 811 298 114,28
39202	Хуримтлагдсан элэгдэл	(79 471 716,96)	(125 438 730,04)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	49 467 300,00	49 467 300,00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(22 286 241,76)	(29 621 968,83)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	110 950 180,00	110 950 180,00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(37 301 469,73)	(47 117 525,15)
393	Биет бус хөрөнгө	<u>310 155 000,08</u>	<u>310 017 500,12</u>
39301	Програм хангамж	1 230 000,00	550 000,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(954 999,92)	(412 499,88)
39303	Бусад биет бус хөрөнгө	309 880 000,00	309 880 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2 198 648 735,16</u>	<u>2 133 409 465,38</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1 320 979,00</u>	<u>280 047,00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	<u>1 320 979,00</u>	<u>280 047,00</u>
413	Өглөг	<u>1 320 979,00</u>	<u>280 047,00</u>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1 320 979,00	280 047,00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2 197 327 756,16</u>	<u>2 133 129 418,38</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>2 197 327 756,16</u>	<u>2 133 129 418,38</u>
511	Засгтйг газрын хувь оруулсан капитал	<u>309 880 000,00</u>	<u>309 880 000,00</u>
512	Хуримтлагдсан үр дүн	<u>1 014 356 709,23</u>	<u>950 158 371,45</u>
51210	Өмнөх үеийн үр дүн	1 014 356 709,23	1 014 356 709,23
51220	Тайлант үеийн үр дүн	-	(64 198 337,78)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	873 091 046,93	873 091 046,93
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2 198 648 735,16</u>	<u>2 133 409 465,38</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	618 324 000,00	557 192 550,15
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	64 145 100,00	1 854 050,15
120	Нийтлэг татварын бус орлого	64 145 100,00	1 854 050,15
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	64 145 100,00	1 854 050,15
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	64 145 100,00	1 854 050,15
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	554 178 900,00	555 338 500,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	509 841 500,00	510 461 100,00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	509 841 500,00	510 461 100,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	540 000,00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	140 000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	400 000,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44 337 400,00	44 337 400,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44 337 400,00	44 337 400,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	616 525 853,74	621 390 887,93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	616 525 853,74	621 390 887,93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	601 121 786,02	606 328 614,05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	417 908 338,30	425 587 193,18
210101	Үндсэн цалин	274 127 199,12	305 036 451,19
210102	Нэмэгдэл	102 802 467,39	84 061 387,99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1 586 000,00	1 234 400,00
210104	Урамшуулал	39 392 671,79	35 254 954,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51 781 962,87	54 553 502,92
210201	Тэтгэврийн даатгал	35 608 814,67	38 229 860,82
210202	Тэтгэмжийн даатгал	4 393 452,18	4 212 197,09
210203	ҮОМШӨ-ний даатгал	3 344 697,38	3 366 337,63
210204	Ажилгүйдлийн даатгал	766 817,98	794 991,60
210205	Эрүүл мэндийн даатгал	7 668 180,66	7 950 115,78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28 099 755,11	28 031 267,02
210301	Гэрэл, цахилгаан	3 672 510,87	3 907 319,84
210302	Түлш, халаалт	18 439 977,15	16 327 132,38
210303	Цэвэр, бохир ус	5 987 267,09	7 796 814,80
2104	Хангамж, бараа материалын зардал	15 698 750,00	4 477 300,00
210401	Бичиг хэрэг	108 100,00	284 700,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	143 600,00	117 200,00
210404	Ном, хэвлэл	50 000,00	90 500,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8 275 850,00	1 032 000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7 121 200,00	1 430 900,00

210408	Бараа материал акталсны зардал	-	1 522 000,00
2105	Нормативт зардал	22 853 448,00	25 297 010,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	196 900,00	83 200,00
210502	Хоол, хүнс	22 614 548,00	24 415 310,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	42 000,00	798 500,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2 193 900,00	2 079 900,00
210604	Урсгал засвар	2 193 900,00	2 079 900,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1 307 300,00	1 008 000,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	299 300,00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1 008 000,00	1 008 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61 278 331,74	65 294 440,93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	458 400,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4 605 300,00	2 677 900,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	56 673 031,74	62 158 140,93
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15 404 067,72	15 062 273,88
2132	Бусад урсгал шилжүүлэг	50 000,00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	50 000,00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14 157 744,89	14 226 232,98
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14 157 744,89	14 226 232,98
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1 196 322,83	836 040,90
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1 196 322,83	836 040,90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1 798 146,26	(64 198 337,78)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4 089 888,00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2 908 510,00	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1 181 378,00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(4 089 888,00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(2 291 741,74)	(64 198 337,78)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгий газрын сан	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оруулсан сан
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	309 880 000,00	873 091 046,93	1 014 356 709,23	2 197 327 756,16
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(64 198 337,78)	(64 198 337,78)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	309 880 000,00	873 091 046,93	950 158 371,45	2 133 129 418,38

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	564 593 430,00	600 143 026,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	564 593 430,00	600 143 026,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	509 841 500,00	510 461 100,00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	509 841 500,00	510 461 100,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	540 000,00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	140 000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	400 000,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	44 337 400,00	44 337 400,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	44 337 400,00	44 337 400,00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	10 414 530,00	44 804 526,00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	10 414 530,00	44 804 526,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	564 593 430,00	600 143 026,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	564 593 430,00	600 143 026,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	538 774 832,28	540 276 226,12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	417 908 338,30	425 307 146,18
210101	Үндсэн цалин	274 127 199,12	289 587 018,01
210102	Нэмэгдэл	102 802 467,39	99 263 828,17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1 586 000,00	1 221 600,00
210104	Урамшуулал	39 392 671,79	35 234 700,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51 781 962,87	54 553 502,92
210201	Тэтгэврийн даатгал	35 608 814,67	40 067 600,93
210202	Тэтгэмжийн даатгал	4 393 452,18	3 732 880,42
210203	ҮОМШӨ-ний даатгал	3 344 697,38	2 982 884,32
210204	Ажилгүйдлийн даатгал	766 817,98	706 357,93
210205	Эрүүл мэндийн даатгал	7 668 180,66	7 063 779,32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28 099 755,11	28 031 267,02
210301	Гэрэл, цахилгаан	3 672 510,87	3 907 319,84
210302	Түлш, халаалт	18 439 977,15	16 327 132,38
210303	Цэвэр, бохир ус	5 987 267,09	7 796 814,80
2104	Хангамж, бараа материалын зардал	9 294 550,00	1 352 800,00
210401	Бичиг хэрэг	108 100,00	284 700,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	143 600,00	117 200,00
210404	Ном, хэвлэл	50 000,00	90 500,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8 673 650,00	600 000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	319 200,00	260 400,00
2105	Нормативт зардал	25 185 726,00	24 941 810,00

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	196 900,00	83 200,00
210502	Хоол, хүнс	24 206 026,00	24 060 110,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	782 800,00	798 500,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2 079 900,00	2 079 900,00
210604	Урсгал засвар	2 079 900,00	2 079 900,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1 307 300,00	1 008 000,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	299 300,00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1 008 000,00	1 008 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3 117 300,00	3 001 800,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	458 400,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3 117 300,00	2 543 400,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25 818 597,72	59 866 799,88
2132	Бусад урсгал шилжүүлэг	10 464 530,00	44 804 526,00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	10 414 530,00	44 804 526,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	50 000,00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14 157 744,89	14 226 232,98
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14 157 744,89	14 226 232,98
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1 196 322,83	836 040,90
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1 196 322,83	836 040,90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	554798500,00	539736226,12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	554798500,00	539736226,12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	554798500,00	539736226,12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	425580500,00	425307146,18
210101	Үндсэн цалин	244313700,00	289587018,01
210102	Нэмэгдэл	142205300,00	99263828,17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3826800,00	1221600,00
210104	Урамшуулал	35234700,00	35234700,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54651200,00	54553502,92
210201	Тэтгэврийн даатгал	37628000,00	40067600,93
210202	Тэтгэмжийн даатгал	4255800,00	3732880,42
210203	ҮОМШӨ-ний даатгал	3404600,00	2982884,32
210204	Ажилгүйдлийн даатгал	851200,00	706357,93
210205	Эрүүл мэндийн даатгал	8511600,00	7063779,32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42257500,00	28031267,02
210301	Гэрэл, цахилгаан	6065600,00	3907319,84
210302	Түлш, халаалт	24993400,00	16327132,38

210303	Цэвэр, бохир ус	11198500,00	7796814,80
2104	Хангамж, бараа материалын зардал	881000,00	812800,00
210401	Бичиг хэрэг	144700,00	144700,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	117 200,00	117 200,00
210404	Ном, хэвлэл	90 500,00	90 500,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	268 200,00	200 000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	260 400,00	260 400,00
2105	Нормативт зардал	25 169 500,00	24 941 810,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	83 200,00	83 200,00
210502	Хоол, хүнс	24 287 800,00	24 060 110,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	798 500,00	798 500,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2 079 900,00	2 079 900,00
210604	Урсгал засвар	2 079 900,00	2 079 900,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1 029 300,00	1 008 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1 029 300,00	1 008 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3 001 800,00	3 001 800,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	458 400,00	458 400,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2 543 400,00	2 543 400,00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	554 798 500,00	539 518 869,12
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	510 461 100,00	509 625 059,10
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	510 461 100,00	509 625 059,10
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	44 337 400,00	30 111 167,02
132001	Орон нутгийн төсвөөс	44 337 400,00	30 111 167,02
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	(217 357,00)
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	(217 357,00)

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	540 000,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	540 000,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	540 000,00
2104	Хангамж, бараа материалын зардал	540 000,00
210401	Бичиг хэрэг	140 000,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	400 000,00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	400 000,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	400 000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	400 000,00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж

заасны дагуу Орхон аймгийн Унага цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь “Бейкер Тилли Далайван аудит” ХХК-ийн аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, эхний шатны хяналтыг ахлах аудитор, захирал Д.Мягмарсүрэн хэрэгжүүлж, 2 болон 3-р шатны хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, Орхон аймгийн төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн Унага цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн Унага цэцэрлэг нь сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд тухайн нас бүрт нь таарсан боловсрол, өөрийгөө илэрхийлэх арга барил, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх, суралцах таатай орчин бүрдүүлэх үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн Унага цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 554,798.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,548.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3,883.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн Унага цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 65,239.2 мянган төгрөгөөр буюу 2.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	1,326.0	5.0	(1,321.0)
Бараа материал	55,609.7	53,849.6	(1,760.1)
Үндсэн хөрөнгө	2,141,713.0	2,079,554.9	(62,158.1)
Нийт хөрөнгө	2,198,648.7	2,133,409.5	(65,239.2)
Өр төлбөр	1,321.0	280.0	(1,041.0)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,197,327.7	2,133,129.5	(64,198.2)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,198,648.7	2,133,409.5	(65,239.2)

Бараа материалын данс 53,849.6 мянган төгрөг болж өмнөх оноос 1,760.1 мянган төгрөгөөр буурсан нь эрхлэгчийн А/54 дугаар тушаалын дагуу 1,522.0 мянган төгрөгийн өртөг бүхий тусгай зориулалтын материал акталсан болон тайлант хугацааны бараа материалын зарцуулалттай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,079,554.9 мянган төгрөг болж өмнөх оны 62,158.1 мянган төгрөгөөр буурсан нь Орхон аймгийн Засаг даргын А/660 дугаар захирамжийн дагуу 1,098.1 мянган төгрөгийн өртөг бүхий хайс шилжүүлэн авч, 680.0 мянган төгрөгийн программ хангамжийг акталж, 51,330.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын хэмжээнээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,133,129.5 мянган төгрөг болж 64,198.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Орхон аймгийн Унага цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 833,827.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 833,827.3 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 279,028.8 мянган төгрөгөөр бууруулан 554,798.5 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд төсвийг 2 удаа тодотгол хийж 44,337.4 мянган төгрөгөөр бууруулж, 510,461.1 мянган төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх СӨБ-ын арга хэмжээг хэрэгжүүлэхээр 510,461.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 44,337.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, нэмэлт дансаар 540.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 540,276.2 мянган төгрөгийг зарцуулж, 836.0 мянган төгрөгийг улсын төсөвт, 14,226.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 540,276.2 мянган төгрөг буюу 97.4 хувьтай байгаа ба хөл хорионы үеэс шалтгаалсан байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 14,226.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Боловсрол шинжлэх ухааны газраас ариутгал халдваргүйтгэлийн зардалд 400.0 мянган төгрөг, тендер зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотой орлого 140.0 мянган төгрөгийг тус тус нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Үүнээс бичиг хэргийн зардалд 140.0 мянган төгрөг, ариутгал халдваргүйтгэлийн зардалд 400.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө нөхсөн тэг үлдэгдэлтэй ашиглагдахгүй байгаа болон ашиглагдаж байгаа 7 нэр төрлийн 4,176.9 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Мөн үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл дээр бүртгэлтэй боловч бодитоор байхгүй 1 нэр төрлийн 1,375.0 мянган төгрөгийн өртөг бүхий 25 ширхэг ор бүртгэлтэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Унага цэцэрлэг нь 2021 онд нийт 554,798.5 мянган төгрөгийн 147 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй, 554,798.5 мянган төгрөгийн 145 мэдээллийг ил тод байршуулж, хуулийн хугацаанд 100 хувийн гүйцэтгэлтэй мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 142,221.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 42,049.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 96,067.8 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт, 4,104.0 мянган төгрөгийн 1 албан шаардлагын биелэлтийг 99.7 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Албан шаардлага	1	4,104.0	1	4,104.0			
Зөвлөмж	2	96,067.8	1	95,782.8	1	285.0	0.3
Нийт дүн	3	100,171.8	3	99,886.7			

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө нөхсөн тэг үлдэгдэлтэй ашиглагдахгүй байгаа болон ашиглагдаж байгаа хөрөнгүүдийг акталж устгасан болон дахин үнэлгээ хийгдэж, ашиглалтын хугацааг дахин тогтоосон эсэх.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 6,295.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 743.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 албан шаардлага, 5,551.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

Тайлант онд залруулсан алдаа гараагүй байна.

4.2 Албан шаардлага

1. Авлага өглөгийн бүртгэлтэй холбоотой асуудал

Өмнөх оны зөвлөмжийг биелүүлээгүй тайлангийн хугацааны эцэст 5.0 мянган төгрөгийн авлага, 280.0 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлэв.

2. Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилттэй холбоотой асуудал

Төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах Засгийн газрын 43-р тогтоолоор батлагдсан "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолыг хэрэгжүүлээгүй уралдаан тэмцээний арга хэмжээнд 458.4 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийсэн тул албан шаардлага хүргүүлэв.

4.3 Акт

Тайлант онд гарсан алдаа зөрчилд акт хүргүүлээгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн ашиглалт, дахин үнэлгээтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Тайлант оны үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө нөхсөн тэг үлдэгдэлтэй ашиглагдахгүй байгаа болон ашиглагдаж байгаа 7 нэр төрлийн 4,176.9 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. УСНББОУС 17 "Үндсэн хөрөнгө"-ийн 49-д "Дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээс материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай" гэсэн заалтыг баримталж ажиллаагүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Үлдэх өртөггүй болсон хөрөнгүүдийг дахин үнэлгээ хийх шийдвэрийг гаргуулан дахин үнэлгээг хийлгэн санхүүгийн тайланд тусгаж байх. Мөн тэг үлдэгдэлтэй ашиглагдахгүй байгаа хөрөнгийг заавар журмын дагуу актлуулах саналыг гаргуулан актлаж устгах.

2. Үндсэн хөрөнгийн бодитоор оршин байхтай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл дээр бүртгэлтэй боловч бодитоор байхгүй 1 нэр төрлийн 1,375.0 мянган төгрөгийн өртөг бүхий 25 ширхэг ор бүртгэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" гэсэн заалттай нийцэхгүй

байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн биет тооллогыг үр дүнтэй гүйцэтгэж, хөрөнгийг тайланд бодитоор тайлагнах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн нэгтгэл		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Орхон аймгийн Унага цэцэрлэг	4	6,295.3					2	743.4	2	5,551.9
Нийт		4	6,295.3					2	743.4	2	5,551.9

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:

“БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ” ХХК-ИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН

АУДИТОР:

Б.Пүрэвсүрэн

Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР, ЗАХИРАЛ:

Д.Мягмарсүрэн

Д.МЯГМАРСҮРЭН

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Б.Эрдэнэ

Б.ЭРДЭНЭ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Ц.Нармандах

Ц.НАРМАНДАХ

